

ЭРДЭНЭ РЕСУРС МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР 5 САЯ АМ.ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЛЭЭ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2021.10.12

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Монголын Хөрөнгийн Бирж дээр 5 сая ам.доллартай тэнцэх энгийн хувьцаа гарган, 1,867 Монголын мэргэжлийн болон хувийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлж, анхдагч зах зээлийн захиалга даван биелснийг мэдээлэхэд таатай байна.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Монголын хөрөнгийн бирж дээрх санхүүжилтийг амжилттай хааснаар Монгол хувьцаа эзэмшигчдээ тэлж байгаад бид баяртай байна. Би саяхан Монголд ажиллахдаа олон оролцогч талуудтай уулзсан. Бидэнтэй урт хугацаанд хамтран ажиллан, үргэлж дэмжлэг үзүүлдэг хувьцаа эзэмшигчдээ талархал илэрхийлэхийн зэрэгцээ Эрдэнэ Ресурсийн өсөлтийн шинэ үед бидэнтэй нэгдэж буй шинэ хувьцаа эзэмшигчдээ мэндчилгээ дэвшүүлье. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Баян Хөндий алтны төслийн бүтээн байгуулалт болон Хөндий Алтны Дүүргийн хайгуулыг үргэлжлүүлэхэд зарцуулна.”

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай: “Эрдэнэ Ресурс-д Монголын хөрөнгийн биржийн санхүүжилтийг амжилттай хаасанд баяр хүргэе. Монгол болон Торонтогийн хөрөнгийн биржүүдэд давхар бүртгүүлсэн анхны компанийн хувьд Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын ашигт малтмалын төсөл хөгжүүлэлтийн санхүүжилтэд дотоодын хөрөнгийн зах зээл ямар ач холбогдолтойг нотолсоор байна.”

Санал болгох нөхцөл:

Санхүүжилттэй холбоотойгоор Компани нь нэгж бурийг 815 төгрөг (C\$0.36)-өөр үнэлсэн 17,484,662 ширхэг энгийн хувьцааг гаргасан нь ойролцоогоор 5 сая ам.доллартай тэнцэнэ. Энэхүү санхүүжилтийн тэргүүлэх андеррайтераар БидиСек УЦК, хамтрагч брокероор Мандал Капитал Маркетс УЦК, Таван Богд Капитал УЦК нар ажиллав. Энгийн хувьцааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулгын хүрээнд гаргасан. Компани нь андеррайтеруудад нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 7%-ийн шимтгэл төлсөн. Санхүүжилтийн захиалга нь 46%-иар даван биелсэн боловч хувь тэнцүүлэн, гаргах энгийн хувьцааны тоог 17,484,662 ширхгээр хязгаарласан.

Эрдэнэ Ресурс нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компанийн 100% эзэмшдэг Баян Хөндий алтны төслийн хөгжүүлэлт, Улаан болон Хар Морь алтны нээлтүүдийг нарийвчлан тодорхойлох, Хөндий алтны дүүргийн нэмэлт хайгуулын хөтөлбөрүүд болон захиргаа, эргэлтийн хөрөнгөнд зарцуулна.

Хөндий алтны дүүрэг

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, З ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгднөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй. Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>